



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-16
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	17-34

1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	19
2.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	19-34

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
03 дугаар сарын 28-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 18 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, Ж.Батсуурь, Э.Батиугар, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Н.Ганибал, Г.Дамдинням, Г.Мөнхцэцэг, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Ц.Туваан, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан, Ж.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ё.Баатарбилэг, Ж.Ганбаатар, Б.Жавхлан, Б.Жаргалмаа, Г.Занданишатар, Ц.Идэрбат;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Д.Батлут, Х.Болорчулуун, С.Одонтуяа, Ш.Раднаасэд;

Хоцорсон: С.Амарсайхан- 14 минут, Т.Доржханд- 25 минут, Н.Учрал- 22 минут, Б.Энх-Амгалан- 16 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ц.Даваасүрэн нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх тухай асуудлаар Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./10:28/

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.12.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, мөн хорооны орон тооны гишүүн Т.Цэрэнбадрал, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, ахлах зөвлөх А.Нинжин, ахлах референт Н.Энхбаатар, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Долгорсүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, референт Р.Цэвэлмаа, Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Банкны бодлогын хэлтсийн захирал Д.Ганбат, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, мөн газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн зөвлөх Н.Ундраа, Хадгаламжийн даатгалын корпорацийн Нөхөн төлбөр, бүтцийн өөрчлөлтийн хэлтсийн захирал Д.Баасандулам, “Монголын хөрөнгийн бирж” Хувьцаат компанийн Үйл ажиллагааны газрын захирал И.Жавхлан, “Монголын үнэт цаасны клирингийн төв” Хязгаарлагдмал хувьцаат компанийн Клиринг эрсдэлийн удирдлагын албаны захирал Ч.Андсайхан, “Хаан банк” Хувьцаат компанийн кастодиан үйлчилгээний газрын захирал Ч.Ариунжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг, Г.Амартүвшин, Д.Ганбат нарын тавьсан асуултад Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, мөн хорооны орон тооны гишүүн Т.Цэрэнбадрал нар хариулж, тайлбар хийв.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Баттөмөр, Н.Ганибал, Т.Доржханд, Ч.Ундрам /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.35 дахь заалтын “санхүүгийн хэрэгслээс” гэсний өмнө “суурь хөрөнгө,” гэж нэмж, 4.1.39 дэх заалтын “олон улсын гэрээний дагуу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18

Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 19¹ дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19¹ дүгээр зүйл.Үнэт цаасны зах зээлд банкнаас гаргасан хадгаламжийн сертификат арилжих

19¹.1.Банкны тухай хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй банк хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргаж болно.

19¹.2.Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнахтай холбогдох журмыг Төв банк /Монголбанк/ болон Хадгаламжийн даатгалын корпорацийн саналыг харгалзан Хороо батална.

19¹.3.Банк хадгаламжийн сертификат үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргахад Төв банк /Монголбанк/-ны санал, дүгнэлтийг Хороонд ирүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.10 дахь хэсгийн “зохицуулалттай этгээдийн” гэсний өмнө “энэ хуулийн 24.1.1-24.1.11, 24.1.13, 24.1.19-т заасан үйл ажиллагааг эрхлэх” гэж нэмж, 24.10.2 дахь заалтыг болон 24.11.4 дэх заалтын “төлөөлөгчийн газар байгуулах шийдвэр гаргасан этгээд салбар” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.2.9, 27.2.11 дэх заалтыг болон 11 дэх заалт буюу 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалт буюу 33 дугаар зүйлийн 33.10 дахь хэсгийг хасаж, 13 дахь заалт буюу 33 дугаар зүйлийн 33.7.5 дахь заалтын “33.2, 33.3, 33.10-т заасан шалгуур,” гэснийг “33.2-т заасан шалгуур, 33.3, 50¹.3-т заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 36 дугаар зүйлийн 36.18 дахь хэсэг, 16 дахь заалт буюу 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэг, 17 дахь заалт буюу 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг, 18 дахь заалт буюу 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсэг, 19 дэх заалт буюу 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалт буюу 45 дугаар зүйлийн 45.10 дахь хэсгийн “бүртгэж, тухайлсан бүртгэл хөтөлнө.” гэснийг “бүртгэж, бенефициар өмчлөгчийн дансанд хадгална.” гэж өөрчилж, 20 дахь заалт буюу 42 дугаар зүйлийн 42.19 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22 дахь заалт буюу 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 46.10 дахь хэсгийг хасах:

“46.9.Хороо болон кастодианы үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд шаардсан тохиолдолд энэ хуулийн 46.8-д заасан харилцагч нь бенефициар өмчлөгчийн мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 23 дахь заалт буюу 47 дугаар зүйлийн 47.8 дахь хэсгийн “урьдчилсан нөхцөл шаардлага хангуулах” гэснийг болон 24 дэх заалт буюу 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 25 дахь заалт буюу 50¹ дүгээр зүйлийн 50¹.1 дэх хэсгийн “зохион байгуулах зорилготой байна.” гэснийг “зохион байгуулна.” гэж, 50¹.3 дахь хэсгийн “холбоотой харилцааг зохицуулсан” гэснийг “холбогдсон” гэж, 50¹.4 дэх хэсгийн “11.1-д” гэснийг “11 дүгээр зүйлд” гэж тус тус

өөрчилж, 27 дахь заалт буюу 51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 31 дэх заалт буюу 88² дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “33.10” гэснийг “50¹.3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “хөрөнгө оруулагчид” гэснийг хасаж, 7 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Урьд нь нийтэд” гэснийг “Үнэт цаас гаргагч урьд нь нийтэд” гэж, 9.4 дэх хэсгийн “хуулийн этгээд” гэснийг “үнэт цаас гаргагч” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн “хянах ба зөрчил гараагүй” гэснийг “хянах ба зохих журмын дагуу явагдсан” гэж, 10 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “үнийн дүн бүхий өрийн хэрэгслүүдийг бүхэлд нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг нэг удаа, эсхүл хэд хэдэн удаагийн давтамжтайгаар нийтэд хэсэгчлэн санал болгон худалдаж болно.” гэснийг “үнийн дүн бүхий нийт өрийн хэрэгслийг хөтөлбөрийн хүрээнд бүхэлд нь нэг удаа бүртгүүлж болно.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Компанийн өрийн хэрэгслийг хэд хэдэн удаагийн давтамжтайгаар нийтэд хэсэгчлэн санал болгон” гэснийг “Энэ хуулийн 16.4-т заасны дагуу бүртгүүлсэн компанийн өрийн хэрэгслийг нийтэд санал болгон” гэж, 16.6 дахь хэсгийн

“Хороо зөвшөөрсөн тохиолдолд энэ хуулийн 24.1.5, 24.1.10-г заасан болон бусад этгээд” гэснийг “Хорооноос зөвшөөрсөн этгээд” гэж тус тус өөрчилж, 11 дэх заалт буюу 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “нийгэд санал болгон” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 20
Бүгд: 42
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “шаардлагыг тогтоох” гэснийг “шаардлага, суурь хөрөнгийн төрлийг тогтоох” гэж, 13 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалтын “аудит хийлгүүлж, дүгнэлтийн хамт” гэснийг “аудит хийлгүүлж, аудитын дүгнэлт гарснаас хойш аудитын дүгнэлтийн хамт” гэж тус тус өөрчилж, 14 дэх заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 19 дэх заалт буюу 36 дугаар зүйлийн 36.16 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 43.1.2 дахь заалтыг хасах:

“43.1.1.үнэт цаасны арилжааны хэлцэлд худалдан авагч талын эсрэг худалдагч тал, худалдагч талын эсрэг худалдан авагч талын үүрэг гүйцэтгэх, үүнтэй холбогдсон эрх хэрэгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.1.3 дахь заалтын “болон арилжааны бус” гэснийг, 43.1.4 дэх заалтын “эрх бүхий” гэснийг”, 43.1.5 дахь заалтын “талуудын болон системийн” гэснийг болон 43.7 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 20
Бүгд: 41
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “ажиллагааг шударга, үр ашигтай, үр дүнтэй, зохион байгуулах, системийн эрсдэлийг бууруулах үүрэгтэй.” гэснийг “ажиллагааг явуулахдаа шударга, үр ашигтай, үр дүнтэй, эрсдэлийг бууруулах зарчмыг баримтална.” гэж өөрчилж, 43.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.3.Клирингийн байгууллага гишүүнчлэлтэй (цаашид “клирингийн гишүүн” гэх) байх бөгөөд клирингийн гишүүн элсүүлэх шалгуурыг клирингийн байгууллагын журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 22
Бүгд: 41

46.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41

56.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсгийн “клирингийн гишүүн нь гэрээт үнэт цаасны компани болон харилцагчаас” гэснийг “клирингийн байгууллага нь клирингийн гишүүнээс” гэж, 43.5 дахь хэсгийн “үнэт цаасны компани” гэснийг “клирингийн гишүүн нь” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41

53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.6.Энэ хуулийн 43.2-т заасан зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор клирингийн байгууллага нь төлбөрийн баталгааны сан байгуулах бөгөөд сангийн үйл ажиллагааны

журмыг батална. Төлбөрийн баталгааны сангийн эх үүсвэр нь клирингийн гишүүний санд оруулсан мөнгөн хуримтлалаас бүрдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 43.11 дэх хэсгийг хасах:

“43.9.Клирингийн байгууллага нь хуульд заасан эрх бүхий байгууллага задруулахыг шаардсанаас бусад тохиолдолд клирингийн гишүүнд холбогдох өөрт байгаа мэдээллийн нууцлалыг хадгална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “үйл ажиллагаа гэж тусгай зөвшөөрлийн бүхий” гэснийг “үйл ажиллагаа гэж энэ хуулийн 24.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий” гэж, 44.1.1 дэх заалтын “ирүүлсэн үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн үүргийг шалган баталгаажуулах” гэснийг “ирүүлсэн даалгаврын дагуу үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн гүйлгээг нэгэн зэрэг гүйцэтгэх” гэж тус тус өөрчилж, үүнтэй уялдуулан 44.1.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 44 дүгээр зүйлийн 44.1.3 дахь заалтын “, сааталтай холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох” гэснийг хасаж, 44.1.4 дэх заалтын “холбогдох” гэснийг “энэ хуулийн 43.1-д заасан” гэж, мөн зүйлийн 22 дахь заалт буюу 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсгийн “мэдүүлсэн дансанд” гэснийг “нэр дээрх дансанд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 25 дахь заалт буюу 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгийн “нягтлан бодох болон бусад бүртгэлдээ аудитын шалгалт хийлгэж, санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт” гэснийг “нягтлан бодох бүртгэлдээ аудитын шалгалт хийлгэж, санхүүгийн тайланг аудитын дүгнэлт гарснаас хойш

аудитын дүгнэлтийн хамт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “22.9 дэх хэсгийн” гэсний дараах болон “51 дүгээр зүйлийн” гэсний өмнөх “, 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн “54 дүгээр зүйлийн” гэсний өмнө “51 дүгээр зүйлийн 51.1.2 дахь заалтын “төлбөрийн” гэснийг “төлбөр тооцооны” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “мөн зүйлийн 9.13 дахь хэсгийн “, 9.9” гэснийг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 12 дугаар зүйлийн 12.7.2 дахь заалтын “тохиолдолд” гэсний дараа “татан” гэж”, төслийн 4 дүгээр зүйлийн “17.1 дэх хэсгийн” гэсний дараа ““Монгол Улсын”, “гадаад улсын” гэсний дараах” гэж, мөн зүйлийн “18.1 дэх хэсгийн” гэсний дараа ““Гадаад улсын”, “эрхэлж байгаа” гэсний дараах” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.38 дахь заалтын “төлбөр гүйцэтгэх болон хадгалах” гэснийг “хадгалах болон төлбөр гүйцэтгэх” гэж, мөн зүйлийн 8 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.12 дахь хэсгийн “бичиг баримтыг” гэснийг “баримт бичгийг” гэж, төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 16.3.2 дахь заалтын “санхүүгийн” гэснийг “санхүүжих” гэж, мөн зүйлийн 12 дахь заалт буюу 19.2 дахь хэсгийн “арилжаалагдах” гэснийг “арилжих” гэж, төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43.1 дэх хэсгийн, 43.2 дахь хэсгийн, 43.8 дахь хэсгийн “төв” гэснийг “байгууллага” гэж, 43.8 дахь хэсгийн “төлбөрийн үүрэг” гэснийг “төлбөр” гэж, мөн хэсгийн “төлбөр гүйцэтгэх байгууллагын” гэснийг “төлбөр тооцооны байгууллагын” гэж, 4 дүгээр зүйлийн “нийгмийн цахим сүлжээ” гэснийг “цахим орчин дахь олон нийтийн сүлжээ” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5.1.11 дахь заалтын “энэ хуульд заасан” гэснийг, мөн зүйлийн 15 дахь заалт буюу 36.17 дахь хэсгийн, мөн зүйлийн 23 дахь заалт буюу 47.9 дэх хэсгийн болон төслийн 2, 4 дүгээр зүйлийн “нарийвчилсан” гэснийг, төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 4.1.27 дахь заалтын “байгууллагын” гэснийг дараах “хөрөнгийн биржийн” гэснийг, мөн заалтын “арилжаанд” гэснийг өмнөх “биржийн” гэснийг, төслийн 3 дугаар зүйлийн 24 дэх заалт буюу 48.2 дахь хэсгийн “хөрөнгийн биржийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 30 дугаар зүйлийн 30.1.7 дахь заалтын дугаарыг “30.1.6” гэж, 9 дэх заалт буюу 39 дүгээр зүйлийн 39.4.5 дахь заалтын дугаарыг “39.4.4” гэж, 13 дахь заалт буюу 55.1.11-55.1.13 дахь заалтын дугаарыг “55.1.10-55.1.12” гэж, мөн зүйлийн 10 дахь заалт буюу 39.8 дахь хэсгийн “Хөрөнгө оруулалтын сангийн” гэснийг “Энэ хуулийн 14¹ дүгээр зүйлд зааснаас бусад хөрөнгө оруулалтын сангийн” гэж, мөн хэсгийн “батлах” гэснийг “батална” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 44¹ дүгээр зүйл, 12 дахь заалт буюу 46 дугаар зүйлийн 46.1.10 дахь заалтын “сангийн удирдлага нь” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “хуулийн этгээдийн хэлбэртэй” гэсний өмнө “энэ хуульд заасан” гэж нэмж, мөн зүйлийн “22.2 дахь хэсгийн “эрхийн” гэсний дараа “өмчлөх эрхийг” гэж” гэснийг “22.2 дахь хэсгийн “нэгж” гэсний дараа “эрхээр гэрчлэгдсэн өмчлөх” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “төвлөрүүлэх санг” гэснийг “төвлөрүүлж, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах санг” гэж өөрчилж, үүнтэй уялдуулан мөн зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “байх бөгөөд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах, сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх зорилготой” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 14
Бүгд: 40
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Хөрөнгө оруулалтын сан” гэснийг “Энэ хуулийн 7.1-д заасан хөрөнгө оруулалтын сан” гэж өөрчилж, 16.1.9 дэх заалтыг болон 16.1.11 дэх заалтын “татан буугдах тухай болон” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт

явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.2.3 дахь заалтын “мөнгөн хөрөнгөөр зээл олгох,” гэснийг болон 15 дахь заалт буюу 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус хасаж, 12 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “26.1.5-26.1.8” гэсний дараа “, 26.1.13” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “нягтлан бодогчоор” гэснийг “нягтлан бодогч, кастодианаар” гэж,” гэснийг хасаж, мөн зүйлийн “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө “30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалтын дугаарыг “30.1.7” гэж, “45 дугаар зүйлийн” гэсний өмнө “39 дүгээр зүйлийн 39.4.4 дэх заалтын дугаарыг “39.4.5” гэж,” гэж, мөн зүйлийн “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “, 55 дугаар зүйлийн 55.1.10 дахь заалтын дугаарыг “55.1.13” гэж” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “19 дүгээр зүйлийн” гэсний өмнө “14 дүгээр зүйлийн 14.9.3 дахь заалтын “нийтээс” гэснийг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 37
Бүгд: 39
5.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар техникийн саатал гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцов.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “19 дүгээр зүйлийн” гэсний өмнө “14 дүгээр зүйлийн 14.9.3 дахь заалтын “нийтээс” гэснийг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь заалт буюу 46.1.12 дахь заалтын “зөвлөлийн” гэсний дараа “гишүүний” гэж, 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.1.10 дахь заалтын “тухайн” гэсний дараа “санхүүгийн” гэж тус тус нэмж, 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 6.2.2 дахь заалтын “өөрийн гаргасан нэгж эрхийг” гэснийг “гаргасан нэгж эрхээ” гэж өөрчилж, 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 14.6 дахь заалтын “бүрэн” гэснийг, 2 дугаар зүйлийн “нарийвчилсан” гэснийг, 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 19.3 дахь хэсгийн “сангийн тухайд” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 46 дугаар зүйлийн 46.17 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 12
Бүгд: 39
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “41 дүгээр зүйлийн” гэсний өмнө “32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “хувьцаа нь” гэсний өмнө “Компанийн” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 3 дугаар зүйлийн 3.9 дэх хэсгийн “компани хэлбэртэй байна.” гэснийг “компани хэлбэртэй байж болно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “заасны дагуу” гэсний дараа “компанийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3, 4, 5 дугаар зүйлийн дугаарыг “1, 2, 3, 4” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 13
Бүгд: 39
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 13
Бүгд: 39
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 11.10 дугаар зүйлийн 12.21 дэх заалтын “зах зээлд, буюу бусад” гэснийг хасаж, мөн зүйлийн “Зөрчлийн тухай хуулийн 11.10, 11.26 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг” гэснийг “Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 12
Бүгд: 39
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн ““12.21” гэснийг “12.22” гэж” гэснийг “12.21 дэх заалтын дугаарыг “12.22” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.Хувь хүний орлогын албан татвараас хөнгөлөх тухай хуулийн төслийн талаар

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 13
Бүгд: 39
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм.Аж ахуйн нэгжсийн орлогын албан татвараас хөнгөлөх тухай хуулийн төслийн талаар

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дуусав.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 26 минут үргэлжилж, 72 гишүүнээс 44 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 11 цаг 44 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 18 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүдийн амрыг эрье. Ирц бүрдсэн байна.

Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1-т, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл. Засгийн газар 2024 оны 03 сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх үргэлжилнэ,

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газар 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. Зарчмын зөрөөтэй 56 саналтай,

3-т нь, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024 оны 03 сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ,

4-д, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024 оны 03 сарын 04-ний өдөр

өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудал байна. Үргэлжилж явагдана.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх, горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг, Цэрэнпилийн Даваасүрэн нараас албан бичиг ирүүлсэн байна. Албан бичгүүдийг уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг гэсэн байна. Норовын Алтанхуяг гишүүн үг хэлье. Алтанхуяг гишүүн байхгүй байна.

Даваасүрэн гишүүний албан бичгийг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа. 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн гэсэн байна. Даваасүрэн гишүүн үг хэлье.

Ц.Даваасүрэн: Та бүгдийн энэ өглөөний амгаланг эрье. Би хэлэлцэх асуудалтай холбогдуулаад нэг хуулийг энэ хаврын чуулганы хэлэлцүүлэгт оруулахгүй байхыг хүсээд байгаа юм. Өмнө нь бид нар бас хэлэлцэх эсэхийг нь шийдсэн. Энэ нэг төрийн өмчийн компани байгуулж болохгүй тухай хуулийн төсөл байгаа. Өнөөдөр Байнгын хороогоор хэлэлцэгдээд явж байгаа. Тэгээд энэ хууль бол Үндсэн

хуулийн зөрчилтэй хууль болчихоод байгаа юм.

1 дүгээрт ямар зөрчил байна вэ гэвэл стратегийн ордуудын 51 хүртэлх хувийг хэрвээ төрийн хайгуул хийсэн бол төр эзэмших ийм хуультай. Гэтэл энэ хуультай бас зөрчилдөөд байгаа юм. Төрийн өмчийн компани байгуулж байж л бид нар тэр стратегийн ордын 50 хүртэлх хувийг эзэмшинэ шүү дээ.

Нөгөө талаар Үндсэн хууль дээр бид нар ард түмэндээ байгалийн баялгийг хүртээнэ гээд заачихсан. Үгүй ээ, тэгээд төрийн өмчийн компани байгуулж байж хүртээхгүй юм бол яаж бид нар тэгээд ард иргэддээ тэр баялгаас хүртээх юм. Тэгэхээр энэ чинь энэ агуулгаараа иргэддээ баялгаас хүртээхгүй гэсэн хууль орж ирж байгаа байхгүй юу. Тийм учраас энэ Үндсэн хуулийн 2 агуулгаар зөрчиж байгаа энэ хуулийг ер нь чуулганы хуралдаанд оруулж хэлэлцэхгүй байхыг л би та бүгдээс хүсэж байна. Хууль санаачилгаас үүнийгээ татаж ав. Үндсэн хуулийн зөрчлөө арилга.

Би бодохдоо нэг стратегийн орд л орж ирэх нь л дээ. Тэгээд стратегийн орд орж ирэхээр яах нь вэ, төрийн өмчийн компани байгуулж болохгүй гээд л бид нар тэр төрийн өмчийн хайгуул хийсэн орд дээр нөгөө 50 хүртэлх хувийг нь эзэмшиж чадахгүй болж байна гэсэн үг байхгүй юу. Өмнө нь МАК-ийн ордыг бид нар яасан, төр мөнгөгүй байна гээд л 34 хувь эзэмшихээсээ татгалзсан. Одоо бол шууд хуулиар хаах гэж байна шүү дээ. Ард иргэддээ баялгаас хүртээнэ гэсэн мөртөө төрийн өмчийн компани байгуулахыг нь хаагаад хаячихаар энэ иргэд чинь яаж баялгаас хүртэх юм. Яг яс юман дээрээ хүнд цаг үед хэн мөнгө төлсөн. Энэ төрийн өмчийн Эрдэнэт, Тавантолгой л иргэдийн цахилгааны мөнгө, тэгээд энэ түлш, халаалтын мөнгийг нь төлсөн шүү дээ. Хувийн компани төлөөгүй шүү дээ.

Тийм учраас төрийн компани байж байж хүнд цаг үед ялангуяа стратегийн ордууд байж байж энэ

иргэдийн чинь хүндрэлтэй цаг үед нь тусалж, цалин тэтгэврийг нь нэмэх гол эх үүсвэр болж байна шүү дээ. Өнөөдөр Эрдэнэс тавантолгой 10 тэрбум долларын орлого оруулж байна. 10 тэрбум долларын орлого оруулж байна. Үүгээр чинь бид нар цалин, тэтгэврээ нэмж чадаж байна. Хөдөө байгаа иргэдийнхээ нэмэгдлийг олгож чадаж байна. Үгүй ээ, тэгээд цаашидаа ингээд төрийн өмчийн компани байхгүй болчихвол хувийнхан ингэх үү, ингэхгүй шүү дээ. Тэгээд энэ бол маш ноцтой хууль. Гишүүд минь үүнийг сайн анхаараарай. Бид нар хэрвээ ийм хууль батлах юм бол энэ сонгууль дөхөж байгаа үед иргэдийнхээ саналыг авахад хүндрэлтэй нөхцөл үүснэ шүү. Хууль санаачлагч бас үүнийгээ анхаараарай.

Яаж тэгээд төрийн өмчийн компани байгуулахгүйгээр та нар тэр төрийн хайгуул хийсэн стратегийн ордын 50 хүртэлх хувийг олон нийтэд эзэмшүүлэх гээд байгаа юм. Төрийн өмчийн компани байгуулж байж л эзэмшүүлнэ шүү дээ. Тэгээд энэ хуулийн асуудлуудыг их анхааралтай хандахгүй бол нөгөө Үндсэн хууль дээрээ байгалийн баялгаа ард түмэнтэй хуваалцана гэххээд ард түмнийхээ хуваалцах гол хаалгыг хаагаад хаячхаж, цоожилж болохгүй шүү дээ, бид нар. Тэгэхээр ийм хууль явж байна. Энэ хуулийг энэ хаврын чуулган энэ маргаашийн хуралдаанаар би хэлэлцэхгүй байхыг хүсье.

Яагаад гэвэл Байнгын хороо дээр энэ хууль чинь яваад байна шүү дээ. Тэгээд үүнийг анхаараач ээ гэж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Даваасүрэн гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэллээ. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг түр хориглох, тэдгээрийн үр ашиг, менежментийг сайжруулах тухай, аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай гэсэн Улсын Их Хурлын тогтоолуудын нэгтгэсэн төслийг Цогтбаатар нарын 12 гишүүн санаачилсан. Мөн энэ хуулийн

хэлэлцүүлгүүд нь яваад эцсийн хэлэлцүүлгүүд хийгдэнэ. Энэ 7 хоногт Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх байсан боловч Эдийн засгийн байнгын хороо хууль санаачлагч байхгүй учраас Байнгын хорооны хэлэлцэх асуудлаас хассан байна. Тийм учраас ирэх 7 хоногт энэ асуудал Байнгын хороогоороо яригдана. Тэр үед Даваасүрэн гишүүний хэлж байгаа энэ асуудлуудыг Байнгын хороо дээрээ ярилцах боломжтой. Байнгын хорооны санал, дүгнэлт орж ирээгүй тохиолдолд Улсын Их Хурлын чуулганаар энэ асуудлыг хэлэлцэх боломжгүй байгаа юм гэдгийг хэлье.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцье.

Уг асуудлаар 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн ажлын 4 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан үг хэлэх үү?

Монгол Ардын намын бүлгийн дарга Тогтохсүрэн үг хэлье.

Д.Тогтохсүрэн: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Гаалийн албан татварыг чөлөөлөх тухай Засгийн газраас хуулийн төсөл өргөн барьсан. Гол нь өргөн хэрэглээний бараа болох гурилын импортын гаалийн татварыг тэглэх, энэ МАА-д үүссэн хүндрэлтэй холбогдуулан малын тэжээлийн үнийн гаалийн татварыг, импортын гаалийн татварууд тэглэх гэсэн ийм 2 асуудал орж ирсэн. Энэ дээр гишүүдийн байр суурь өөр өөр байсан. Тийм учраас Улсын Их Хурал дахь олонхын бүлэг байр сууриа нэгтгэх

зорилгоор завсарлага авсан. Тэгээд завсарлагын 4 хоногийн хугацаа дууссан. Энэ хугацаанд манай бүлэг бас энэ чинь 2 талтай асуудал. 2 талаас нь ярьж байгаад хэлэлцэх эсэхийг нь дэмжих нь зүйтэй юм, үзэл баримтлалын хүрээнд гэж тогтсон. Тийм учраас завсарлагын хугацаа дууссан гэдгийг хэлье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Завсарлагатай холбогдуулан Тогтохсүрэн дарга үг хэллээ. Хугацаа дууссан байна.

Хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлэсний дараа ажлын хэсэг гаргаад үүнийгээ олон талаас нь нухацтай ярья гэсэн зүйлийг хэлж байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалтыг явуулъя.

Гишүүд үг хэлээд дууссан байна. Тийм байна.

Одоо Байнгын хорооны саналаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт гишүүд ээ. Суугаарай гишүүд. Санал хураалт.

63,2 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо болон Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

10.29 цаг

Дараагийнхаа асуудалд оръё.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төмөртогтоогийн Энхтүвшин танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ажлын хэсгийн гишүүдээ оруулаарай.

Т.Энхтүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшингээр ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр, Ганибал, Доржханд, Ундрам нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа.

Байнгын хороо 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гаргаж та бүхэндээ танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед

ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй санал нэг бүрийг хэлэлцэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дэмжлээ. Тухайлбал, олон улсын санхүүгийн зах зээлд бусад төрлийн мөнгөн урсгал орж ирэх боломжтой суурь хөрөнгийг ашиглах, дотоодын зах зээлд үүсмэл санхүүгийн хэрэгслийг бий болгох, бусад төрлийн хөрөнгөд суурилах боломжийг бий болгох зорилгоор суурь хөрөнгийг нэр томъёоны тодорхойлолтод шинээр нэмж тусгахаар бэлтгэснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Олон улсад хөрөнгийн зах зээлд банкны хадгаламжийн сертификат нь үнэт цаасны хэлбэрээр арилжаалагдахаас гадна энгийн хадгаламжийн шинжийн агуулдаг байх, хадгаламжийн сертификатыг даатгалд хамруулах, клирингийн байгууллага нь төлбөрийн баталгааны сан байгуулах, сангийн эх үүсвэр нь клирингийн гишүүдийн хуримтлалаас бүрддэг байхаар өөрчлөн найруулах зарчмын зөрөөтэй саналын томъёолол бэлтгэснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Үнэт цаасны зах зээл дээрх зохицуулалттай үйл ажиллагаа тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлдэг этгээдийн тусгай зөвшөөрлийн харилцаа холбоотой зохицуулалт, тусгай болон нэмэлт шаардлагуудыг Зөвшөөрлийн тухай хууль, Үнэт цаасны тухай цаасны зах зээлийн тухай хуулийн холбогдох зүйлээр зохицуулах нь зүйтэй гэж ажлын хэсгээс үзэж, хасах зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг бэлдсэнийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, ХХОАТ-аас хөнгөлөх тухай, ААНОАТ-аас хөнгөлөх тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын 2024 оны

төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлж, Улсын Их Хурал баталсан тул эдгээр хуулийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаах санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн мөн олонх нь дэмжсэн.

Хуулийн төслийн нийтлэг шаардлагыг хангах, холбогдох бусад хууль тогтоомжтой нийцүүлж нэр томъёог жигдлэх, Ди парламент цахим хуудаст байршуулан хуулийн төсөлд иргэдээс ирүүлсэн саналыг хэлэлцэж, тодорхой шаардлагатай саналуудыг агуулгаар нь хуулийн төслийн хөндөгдсөн зүйл, хэсэг, заалтад тусгалаа.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Энхтүвшин гишүүнд баярлалаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Дэмбэрэлдашийн Баярсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Түдэвийн Цэрэнбадрал, Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны газрын дарга Баттулгын Дөлгөөн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт зохицуулалтын газрын дарга Бархасын Долгорсүрэн, Санхүүгийн зохицуулах

хорооны Хуулийн хэлтсийн дарга Жаргалсайханы Мөнх-Оргил, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Лувсандоржийн Сонор, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн зөвлөх Нүрсэдийн Ундраа, Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны газрын ахлах мэргэжилтэн ахлах референт Намжилын Энхбаатар, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах референт Алтанбулагийн Нинж нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Нэрсээ өгье. Ганбат гишүүнээр тасаллаа. Батсүхийн Саранчимэг гишүүн асуултаа асууя.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр энэ Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн энэ Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонслоо. Тэгэхээр санал, дүгнэлттэй холбоотой бас асуух асуулт байна.

Тэгэхээр өнөөдөр энэ хөрөнгийн биржид бүртгэлтэй энэ 100 гаруй ХК байна гэсэн мэдээлэл байна. Тэгэхээр энэ ХК-уудын ил тод байдлын хангалтгүй компанийн засаглалыг сайжруулах шаардлагатай гэсэн ийм дүгнэлт, шүүмжлэл их гардаг. Тэгэхээр ил тод байдал нь өөрөө энэ засаглалын гол үзүүлэлт учраас энэ төсөлд компанийн засаглалыг сайжруулах эрх зүйн орчин бүрдүүлэх талаар тодорхой ямар зохицуулалтыг тусгасан бэ гэсэн нэг ийм асуулт байна.

Нөгөө талаар энэ иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хөрөнгийн зах зээл дэх иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар бас их ярьдаг. Энэ өөрөө маш ач холбогдолтой. Тийм учраас энэ мэдээлэл бага байгаа энэ цаг үед бас энэ Байнгын хорооны хурлаар иргэд жижиг хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл авах эрх болон бусад эрх зүйн

зохицуулалтын тухай яаж тусгасан бэ?
Энэ дээр нэг хариулт авъя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Саранчимэг гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Санхүүгийн зохицуулах хорооны дарга Дэмбэрэлдашийн Баярсайхан хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье.

Д.Баярсайхан: Саранчимэг гишүүний асуултад хариулъя. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, тэр дотроо олон нийтийн оролцоог илүү сайжруулах, иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах бол маш чухал асуудал байгаа. Манай хөрөнгийн бирж дээр яг өнөөдрийн байдлаар 174 ХК бүртгэлтэй байгаа. Тэгээд ялангуяа энэ хууль дээр номинал дансны зохицуулалтыг маш хялбаршуулсан байдалтай оруулж өгч байгаа. Энэ хэрээрээ иргэдийн хөрөнгийн зах зээл дээр оролцох оролцоог илүү тод нээлттэй болгож өгсөн байгаа.

Дээрээс нь ялангуяа энэ жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой нэлээдгүй өөрчлөлтүүдийг туссан. Харилцагчид хурдан шуурхай данс нээлгэх, цаг алдалгүй арилжаанд орох шат дамжлага багасгах гэх мэт нэлээдгүй өөрчлөлтүүд орж байгаа. Тэгээд дансны доод үлдэгдэл байршуулах, данс хөтөлсний шимтгэл зэрэг нэмэлт хураамж шаардагдахгүй бөгөөд уг дансыг нээлгэхтэй холбоотой ямар нэгэн шимтгэл хураамж нэмж төлдөггүй байхаар зохицуулалтыг хийж өгсөн.

Дээрээс нь мэдээллийг ил тод нээлттэй байдлаар хүргэхийг Монголын хөрөнгийн бирж болон өөр өөрийгөө зохицуулах байгууллагуудад тодорхой чиглэлийг өгсөн. Энэ хүрээндээ ялангуяа ХК-уудын үйл ажиллагаа, том үнийн дүн бүхий хэлцлүүд, компанийн удирдлагатай холбоотой мэдээллийг цаг бүр, тухай бүр давтамжтайгаар олон нийтэд хүргэдэг байх гэсэн зохицуулалтыг хийсэн байгаа гэдгийг хэлэх нь зөв байх.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу.

Одоо Ганибалын Амартүвшин гишүүн асуултаа асууя.

Г.Амартүвшин: Баярлалаа. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль хэлэлцэх эсэхийг нь бид нар шийдэж байна. Тэгэхээр энэ маш чухал хууль байгаа юм. Хэчнээн үнэт цаасны зах зээл манайд хөгжиж байгаа ч гэсэн банкнууд энэ зах зээлийг давамгайлж байгаа хэвээрээ л байна. Хамгийн сүүлийн мэдээллээр банкнуудын Монголбанкны үнэт цаасны багц хэмжээ нь 10 их наяд төгрөг. 10 их наяд төгрөг, өөрөөр хэлбэл эдийн засагт нь эдийн засгийн эргэлтэд орохгүй банкнуудын баланс дээр зүгээр хүү тооцогдоод л байж байна гэсэн үг.

Гэтэл нөгөө талаасаа зээлийн хүү нь буурахгүй хэвээрээ. Одоо жижиг, дунд бизнесийн зээл бол 20 гаруй явчихсан, хэрэглээний зээл 20 гаруй болчихсон. Хамгийн их иргэдийн авахыг хүсдэг зээл бол ипотекийн зээл. 6 хувийн зээл. 6 хувийн зээлийн одоо хүлээгдэж байгаа өргөдлүүд нь 15 мянга. Сар болгон суларч байгаа эх үүсвэрийг нь тооцох юм бол энэ 2 жилийн очер үүсчихсэн байгаа байхгүй юу. 1,5 их наяд төгрөгийн ипотекийн эрэлт байна гэсэн үг. Тэгэхээр энэ банкнуудын болон манай энэ ипотекийн тогтолцооны гажуудлаас бид нар маш хурдан гарах хэрэгтэй байна. Энэ дээр үнэт цаасны зах зээл их том үүрэг рольтой байна гэж харж байгаа.

Тэгэхээр энэ одоо өргөн барьсан хуульд шинэ төрлийн үнэт цаас, шинэ төрлийн хэрэгсэл гаргах ямар боломжуудыг нээж өгсөн бэ?

2 дугаарт, хөрөнгө оруулалтын сангуудын тогтолцоог яаж өөрчилж байгаа вэ? Өөрөөр хэлбэл бид нар зөвхөн МИК болон Монголбанк юм уу, арилжааны банкнуудын ипотека санхүүжилтийг системээс яаж гарах боломж нь энэ дээр нээгдсэн үү, үгүй юү гэдгийг би асуумаар байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Дэмбэрэлдашийн Баярсайхан хариулъя.

Д.Баярсайхан: Ганибал гишүүний асуултад хариулъя. Энэ санхүүгийн салбарын 3 тулгуур баганын нэг болох хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх нь эдийн засгийн суурь бүтцэд маш их чухал нөлөөтэй. Ялангуяа энэ эх үүсвэрийн зардлыг буулгах, тэр дотроо энэ хөрөнгийн зах зээлийн хөгжил нь банкны салбартаа шууд хамааралтай байж байгаа. Энэ дотор нэлээдгүй олон шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахаар тусгасан байгаа.

Хөрөнгийн зах зээл уламжлалт байдлаараа зөвхөн Монголын хөрөнгийн биржийн санхүүжилт татдаг байсан бол биржийн бус зах зээлийг хөгжүүлэхэд нэлээн түлхэц өгөхөөр ийм өөрчлөлтүүд орж байгаа. Энэ хүрээндээ ч гэсэн маш богино хугацаанд 2,5 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний ийм үнэт цаас босгохоор бүртгэл нь хийгдсэн. Яг өнөөдрийн байдлаар 1,9 их наядын санхүүжилт татчихсан байж байгаа.

Дээрээс нь энэ хадгаламжийн сертификат байж байгаа. Хадгаламжийн сертификатыг хөрөнгийн зах зээл дээр оруулж ирж байгаа. Харьцангуй найдвартай, хямд бөгөөд эх үүсвэр татах ийм боломж нээгдэж байгаа. Энэ хэрээрээ бас банкны салбар дахь эх үүсвэрийн зардал буурч, хүүд бас тодорхой нөлөөлөл өгнө өө гэж ойлгож байгаа. Ялангуяа гарааны компаниуд старт апуудад бас графт фандингийн хэлбэрээр олон нийтээс санхүүжилт татах ийм хууль, эрх зүйн зохицуулалт хуульд туссан байгаа. Энэ хэрээрээ бас шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гарах онцлог болсон гэдгийг хэлье гэж бодож байна.

Дээрээс нь энэ биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг блокчэйн технологид арилжааны горимыг нь шилжүүлсэн. Ингэснээр 24/7 хэлбэрээр

үйл ажиллагаагаа явуулж байгаа. Тэгээд хэдийгээр энэ үйл ажиллагаануудыг тусгасан ч гэсэн бас цаашидаа бас нэлээдгүй ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөөд явж байгаа гэдгийг хэлэх нь зөв байна.

Дээрээс нь ялангуяа энэ гадаадын хөрөнгө оруулалт Монголын хөрөнгийн зах зээл дээр маш чухал байгаа. Энэ хүрээндээ давхар бүртгэлийн үйл ажиллагааг маш ойлгомжтой гадаадын хөрөнгө оруулагчдад зориулж зохицуулсан. Энэ хэрээрээ бас тодорхой хэмжээний эх үүсвэр Монголын хөрөнгийн зах зээл дээр орж ирнэ ээ гэж ойлгож байгаа.

Л.Мөнхбаатар: Та болчихсон уу? Хариулт хангалттай юу.

Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Та бүхнийхээ амар амгаланг айлтгая. Хэд хэдэн зүйл байна.

Энэ үнэт цаасны зах зээлээс хүртэж байгаа ард иргэдийн үр өгөөж ямар байна? Үнэт цаасны зах зээл дээр миний ойлгож байгаагаар бас бас ч гэж нэлээн хэдэн наяд төгрөг эргэлддэг болчихсон ийм нөхцөл байдалтай байна гэж ойлгож байгаа. Үүний хажуугаар манай Монголчууд маань залуучууд ихтэй. Тэр сүүлийн үед тэр виртуал хөрөнгө оруулалт дээрээ нэлээн ажиллаж байгаа, орж байгаа, алдаж байгаа ийм нөхцөл байдал бий. Жишээлбэл, тэр ард гэдэг танай Хөрөнгийн биржээр яваад байна уу? Баахан сурталчлаад л ингээд явсан тэр нь хэдэн хувь ч буучихсан байгаа юм. Ямар ч нөхцөлтэй байгаа юм. Энэ нөхцөл байдал ямар байна?

Бас хөрөнгө оруулалтын нөхцөл шаардлага хэрэгтэй байдаг. Энэ компаниуд түүнд яаж оролцож боломжоор хангагдаж байна. 1990-ээд онд нөгөө бүх хуучны үйлдвэрүүдийг ХК болгосон байгаа. Тэр компаниуд маань мэдээж хэрэг өнөөгийн нөхцөлд зах зээлийн нөхцөлд ажиллаж чадахгүй шүү

дээ. Тэр компаниудыг юу болгосон бэ? Тэр ХК болгоод явсан. Тэр нь мэдээж хэрэг үр өгөөж, ноогдол ашгаа өгч чадахгүй шүү дээ. Өнөөгийн нөхцөлд тэгж ажиллах боломжгүй. Угаасаа төлөвлөгөөт эдийн засгийн үед зориулагдаж байсан ийм компаниуд байдаг байсан. Үүнийг ХХК болгодог юм уу, нэг мөр хөрөнгийн биржээ ингэж цэвэрлэх хэрэгтэй.

Нөгөө талаар энэ банкнуудын хувьцаа орж ирсэн. Үүнийг гэхдээ олон нийтийн хяналтад нэр төдий оруулсан шүү дээ. Уул нь 30-аас доошгүй, 35-аас доошгүй хувийг хувьчилж байж, тэгж байж тэр олон нийтийн хяналтад орно. Гэтэл тэрийг нэр төдий нэг 5, 10 хувийг хувьчлаад ХК болгоод ингээд явсан. Түүний үр дүн нөхцөл ямар байна вэ гэсэн ийм асуултууд байна.

Нөгөө талаар олонх зээлийн хүүг 1 хувьд оруулна гээд ингээд зарлаад явсан. Тэр байтугай ломбардыг ч гэсэн хянах ч юм яриад явсан. Уг нь тийм юм байдаггүй л байхгүй юу даа. Ломбард та нарын хяналтад байдаг байх. Гэтэл ард иргэд хоорондоо ажлын байр бий болгоод аваад явж байгаа ийм зүйлийг аваачаад нураачихсан. Тэр байтугай бүр хяналтгүй, нөгөө өдрийн зээл гэдэг юманд нь хамрагддаг ийм нөхцөл байдал руу түлхчихсэн. Мэдээж хэрэг эрсдэлээ тооцоод ингээд бас дүрэм журамтай явдаг байсан ийм үйл ажиллагааг ингээд нураачихсан шүү дээ. Иймэрхүү маягтай л санхүүгийн зах зээл маань явж байна. Яах вэ, ганц нэг авах, барих юмнууд бий, бий, бас бүгдийг нь, би бас нөгөө талаасаа болохгүй зүйлийг нь ингэж ярьж байгаа шүү. Тэрийг нь ч та бүхэн ил тод ярих ёстой.

Тэгээд бусад улс орнууд бараг гэрийн эзэгтэй нар гэрээсээ хөрөнгө оруулалт хийгээд сууж байдаг. Хөрөнгө оруулалтын үр өгөөжөө авч байдаг, ийм байдаг. Гэтэл манайд тэр талаар мэдлэг мэдээлэл их хомс байна. Ер нь хүмүүсийг луйвардах тэр бэлтэс мөрөн өшөө, тэр ямар ард юу юу ч билээ. Түүний хувьцааны ханиш нь хэдэн мянга дахь юм буучихсан.

Нөгөө нөхөд нь бас улс төрд орно гээд л ингээд явж байдаг. Ийм л улс орон, ийм л санхүүгийн зах зээл болчихоод байна шүү дээ.

Гадаадын хөрөнгө оруулалт ер нь орж ирж байна уу, энэ үнэт цаасны зах зээлд. Тэр боломж нь хангагдсан уу. Яг ямар байгаа юм гэх мэтчилний ийм хэдэн асуултууд байна.

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулаарай. Ажлын хэсэг хэд вэ? 3 юм байна, 3 дугаар микрофоныг өгье.

Т.Цэрэнбадрал: Ганбат гишүүний асуултад хариулъя. Хөрөнгийн зах зээлийн үр өгөөж ямар байна вэ гэсэн асуулт тавилаа. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс санхүүгийн салбарын 3 тулгуурын нэг болсон Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, эндээс иргэдийн ...

Л.Мөнхбаатар: Нэр, албан тушаалаа хэлээд микрофоноо өөр лүүгээ ойртуулаад тодорхой хариулаарай.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн Цэрэнбадрал Ганбат гишүүний асуултад хариулъя.

Үүднээс гол бодлого үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллаж байгаа. Хөрөнгийн зах зээл дээр СЗХ-ноос нэлээдгүй бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд бодитойгоор бас тодорхой нааштай эерэг үр өгөөжүүд гарч байна. Тухайлбал өнгөрсөн 23 оны хувьд манай хөрөнгийн зах зээлийн түүхэнд оргил үе буюу үндсэндээ 20 шинэ бүтээгдэхүүн гарч, нээлттэй зах зээлээс манай дотоодын иргэд ААН-үүд 500 тэрбум төгрөгийг татсан байгаа. Энэ дотроо онцолж хэлбэл банкны салбарын Ай Пи Өүгийн хүрээнд 5 банк маань системийн Ай Пи Өүгээ хийсэн. Шинэ бүтээгдэхүүн болох бонд дээр 7 банк нээлттэй бонд татсан. Бас нэгэн шинэ бүтээгдэхүүн болох

хамтын биржээр арилжаалагддаг сан гарсан зэрэг олон шинэ үйлчилгээ бүтээгдэхүүнүүд гарч ирлээ.

Ерөнхийд нь тоймлоод аваад үзэх юм бол сүүлийн 3 жилийн хугацаанд нээлттэй зах зээлээс манай ААН-үүд 1,6 их наяд төгрөгийг татсан. Биржийн бус зах зээл буюу 20 оноос бид зохицуулалтыг нь хийсэн. Энэ хүрээнд 2 их наяд төгрөгийг татсан буюу үндсэндээ 3,6 их наяд төгрөгийг манай бизнесийн салбарынхан татаж, үйл ажиллагаагаа санхүүжүүлсэн буюу хөрөнгийн зах зээлийн оролцоо нэмэгдэж байгаа. Энэ хэрээрээ үр өгөөж нь нэмэгдэж байна гэж харж байгаа.

Мөн үүнтэй холбогдуулаад бас нэгэн мэдээлэл өгөхөд энэ жилийн хувьд 45 компани 800 орчим тэрбум төгрөгийг ноогдол ашиг хэлбэрээр татан хувьцаа эзэмшигчдэд олгохоор шийдвэрлэсэн. Энэ нь өнгөрсөн 3 жилийн хугацаатай харьцуулахад 2,5 дахин өссөн ийм үзүүлэлт байгаа. Энэ хэрээрээ манай иргэдийн хөрөнгийн зах зээл дээр оролцох оролцоо хөрөнгийн зах зээл дээр итгэх идэвхжил нь нэмэгдэж байгаа гэдгийг хэлье.

Ганбат гишүүн бас виртуал хөрөнгийн салбартай холбоотой асуултыг тавилаа. Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад 21 оноос хуулийн дагуу виртуал хөрөнгийн арилжаа эрхлэгч байгууллага буюу биржийг бүртгэх арга хэмжээ авсан. Энэ нь өөрөөр хэлбэл СЗХ виртуал хөрөнгийн 12 биржийг бүртгэсэн. Тухайн 12 бирж дээр үндсэндээ гарсан 46 бүтээгдэхүүн арилжаалагдаж байгаа гэдгийг хэлье.

Виртуал хөрөнгийн орчны тухайд идэвхжилийн хувьд сүүлийн үед харьцангуй сул байгаа. Санхүүгийн зохицуулах хорооны хувьд энэ дээр зөвхөн арилжаа эрхлэгч байгууллагуудыг нь бүртгэдэг. Тухайн бирж дээр арилжаалагдаж байгаа бүтээгдэхүүний хувьд арилжаа эрхлэгч байгууллага буюу бирж нь өөрөө хяналтаа тавьж

журмынхаа хүрээнд бүртгэдэг гэдгийг бас хэлье.

Л.Мөнхбаатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Энэ төрийн өмчтэй компаниуд байгаа. Ер нь авлига, энэ албан тушаал ашиглах энэ тэр гаарсан шүү дээ. Ер нь тэндээс хамаг муу муухай юм гарч байна. Мэдээж хэрэг улсын юм, төрийн юм гэдэг бол бараг л эзэнгүй гэдэг нэртэй ийм байна. Эрдэнэс тавантолгой гэдэг компани чинь компани юм уу, энэ үнэт цаасны зах зээлийн ингээд хууль ном нь гараад л байдаг, аль хуульд нь хамрагддаг компани юм бэ. Эрдэнэс тавантолгой дээр хулгай луйвар, энэ Эрдэнэт энэ тэр дээр ерөөсөө хулгай луйвар бүх юм явж байгаа шүү дээ. Түүний өгөх өгөөж ард түмэнд очиж наалдах юм ерөөсөө нэг 0,01 шахуу л юм наалдаж очиж байна уу, үгүй юү. Нэг сонгууль болохоор нэг хэдэн төгрөг л ярьдаг, амладаг, өгдөг, нэр зүүдэг. Ер нь энэ чинь тэгээд ямар хуулиараа явдаг юм бэ? Танай хяналтад байдаг юм уу?

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гишүүд. Ажлын хэсгийн гишүүд хоорондоо хууч хөөрөөд суугаад байх юм. Тэнд. Ажил дээрээ та нар юмаа ярьж байвал яасан юм бэ? Энэ чуулганы нэгдсэн хуралдаан явагдаж байна.

Асуултад хэн хариулах вэ? Баярсайхан дарга хариулъя.

Д.Баярсайхан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлаас төрийн болон орон нутгийн өмчийн ААН-үүдийг олон нийтийн компани болгох, тэр дотроо Монголын хөрөнгийн биржээр дамжуулж арилжаалах ийм тогтоол батлагдсан. 25 ААН-ийн 34 хувь хүртэлх хэмжээг Монголын хөрөнгийн биржээр дамжуулж арилжаал гээд. Үүний эхлэл болгоод Монголын хөрөнгийн бирж бол амжилттай олон нийтийн компани болсон байгаа. Саяхан бас СЗХ-ноос Монголын цахилгаан холбоо компани бас олон нийтийн компани болохоор ийм

зөвшөөрлөө авсан. 6 сарын хугацаанд олон нийтийн компани болох үйл явцыг хэрэгжүүлэх ёстой. Энэ амжилттай хэрэгжээд явна гэж бодож байгаа.

Цаашидаа ч гэсэн бас бусад тийм ээ, төрийн болон орон нутгийн өмчийн ААН-үүдийг бас олон нийтийн компани болгохоор ажиллаж байна ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчихъя. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Баярсайхан.

Д.Баярсайхан: Эрдэнэс тавантолгой компанийн хувьд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээр хувьцаа нь бүртгэлтэй. Гэхдээ хаалттай ХК хэлбэрээр бүртгэгдсэн байгаа. Яг өнөөдрийн байдлаар нэг 81 аравны 50 хувь нь Эрдэнэс Монгол ХК, 0,06 хувь нь бол ААН-үүд дээр, 18,44 хувь нь иргэд дээр бүртгэлтэй ийм хаалттай хэлбэртэй ХК байгаа. Мэдээж Компанийн тухай хууль болон ХК-д тавигдаж байгаа СЗХ болон бусад хууль тогтоомжийн дагуу энэ шаардлагаа тавиад явж байгаа. Тийм. Энэ хууль дээр бас нэг онцлог нь хаалттай ХК-ийг хэрхэн бүртгэх талаар ийм журмын зохицуулалт орсон байгаа гэдгийг бас хэлэх нь зөв байх.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрөөтэй 56 санал байна. Зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.35 дахь заалтын “санхүүгийн хэрэгслээс” гэсний өмнө “суурь хөрөнгө,” гэж нэмж, 4.1.39 дэх заалтын “олон улсын гэрээний дагуу” гэснийг хасах; Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин, Баттөмөр, Ганибал, Доржханд, Ундрам цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт.

58,1 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 19¹ дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19¹ дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлд банкнаас гаргасан хадгаламжийн сертификат арилжих

19¹.1.Банкны тухай хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй банк хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргаж болно.

19¹.2.Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнахтай холбогдох журмыг Төв банк /Монголбанк/ болон Хадгаламжийн даатгалын корпорацийн саналыг харгалзан Хороо батална.

19¹.3.Банк хадгаламжийн сертификат үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргахад Төв банк /Монголбанк/-ны санал, дүгнэлтийг Хороонд ирүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

58,1 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.10 дахь хэсгийн “зохицуулалттай этгээдийн” гэсний өмнө “энэ хуулийн 24.1.1-24.1.11, 24.1.13, 24.1.19-т заасан үйл ажиллагааг эрхлэх” гэж нэмж, 24.10.2 дахь заалтыг болон 24.11.4 дэх заалтын “төлөөлөгчийн газар байгуулах шийдвэр гаргасан этгээд

салбар” гэснийг тус тус хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64,3 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.2.9, 27.2.11 дэх заалтыг болон 11 дэх заалт буюу 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийг тус тус хасах; санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61,9 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалт буюу 33 дугаар зүйлийн 33.10 дахь хэсгийг хасаж, 13 дахь заалт буюу 33 дугаар зүйлийн 33.7.5 дахь заалтын “33.2, 33.3, 33.10-т заасан шалгуур,” гэснийг “33.2-т заасан шалгуур, 33.3, 50¹.3-т заасан” гэж өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59,5 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 36 дугаар зүйлийн 36.18 дахь хэсэг, 16 дахь заалт буюу 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэг, 17 дахь заалт буюу 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг, 18 дахь заалт буюу 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсэг, 19 дэх заалт буюу 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийг тус тус хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64,3 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалт буюу 45 дугаар зүйлийн 45.10 дахь хэсгийн “бүртгэж, тухайлсан бүртгэл хөтөлнө.” гэснийг “бүртгэж, бенефициар өмчлөгчийн дансанд хадгална.” гэж өөрчилж, 20 дахь заалт буюу 42 дугаар зүйлийн 42.19 дэх хэсгийг хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт, санал хураалт.

64,3 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 22 дахь заалт буюу 46 дугаар зүйлийн 46.9 дэх

хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 46.10 дахь хэсгийг хасах:

“46.9.Хороо болон кастодианы үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд шаардсан тохиолдолд энэ хуулийн 46.8-д заасан харилцагч нь бенефициар өмчлөгчийн мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59,5 хувийн санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 23 дахь заалт буюу 47 дугаар зүйлийн 47.8 дахь хэсгийн “урьдчилсан нөхцөл шаардлага хангуулах” гэснийг болон 24 дэх заалт буюу 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсгийг тус тус хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64,3 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 25 дахь заалт буюу 50¹ дүгээр зүйлийн 50¹.1 дэх хэсгийн “зохион байгуулах зорилготой байна.” гэснийг “зохион байгуулна.” гэж, 50¹.3 дахь хэсгийн “холбоотой харилцааг зохицуулсан” гэснийг “холбогдсон” гэж, 50¹.4 дэх хэсгийн “11.1-д” гэснийг “11 дүгээр зүйлд” гэж тус тус өөрчилж, 27 дахь заалт буюу 51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсгийг хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64,3 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 1 дүгээр зүйлийн 31 дэх заалт буюу 88² дугаар зүйлийг хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59,5 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 2 дугаар зүйлийн “33.10” гэснийг “50¹.3” гэж өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59,5 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “хөрөнгө оруулагчид” гэснийг хасаж, 7 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Урьд нь нийтэд” гэснийг “Үнэт цаас гаргагч урьд нь нийтэд” гэж, 9.4 дэх хэсгийн “хуулийн этгээд” гэснийг “үнэт цаас гаргагч” гэж тус тус өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61,9 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн “хянах ба зөрчил гараагүй” гэснийг “хянах ба зохих журмын дагуу явагдсан” гэж, 10 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “үнийн дүн бүхий өрийн хэрэгслүүдийг бүхэлд нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг нэг удаа, эсхүл хэд хэдэн удаагийн давтамжтайгаар нийтэд хэсэгчлэн санал болгон худалдаж болно.” гэснийг “үнийн дүн бүхий нийт өрийн хэрэгслийг хөтөлбөрийн хүрээнд бүхэлд нь нэг удаа бүртгүүлж болно.” гэж тус тус өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64,3 хувиар санал дэмжигдлээ.

Чинзориг сайд Улсын Их Хурал үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангаж байхыг хүсье. Тогтохсүрэн даргыг бас хэвийн үйл ажлаа явуулах нөхцөлөөр хангахыг хүсье. Араас нь ерөөсөө тувт яриад байх юм.

15.Төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Компанийн өрийн хэрэгслийг хэд хэдэн удаагийн давтамжтайгаар нийтэд хэсэгчлэн санал болгон” гэснийг “Энэ хуулийн 16.4-т заасны дагуу бүртгүүлсэн компанийн өрийн хэрэгслийг нийтэд санал болгон” гэж, 16.6 дахь хэсгийн “Хороо зөвшөөрсөн тохиолдолд энэ хуулийн 24.1.5, 24.1.10-т заасан болон бусад этгээд” гэснийг “Хорооноос зөвшөөрсөн этгээд” гэж тус тус өөрчилж, 11 дэх

заалт буюу 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “нийтэд санал болгон” гэснийг хасаж; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

52,4 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “шаардлагыг тогтоох” гэснийг “шаардлага, суурь хөрөнгийн төрлийг тогтоох” гэж, 13 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалтын “аудит хийлгүүлж, дүгнэлтийн хамт” гэснийг “аудит хийлгүүлж, аудитын дүгнэлт гарснаас хойш аудитын дүгнэлтийн хамт” гэж тус тус өөрчилж, 14 дэх заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг хасаж; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 3 дугаар зүйлийн 19 дэх заалт буюу 36 дугаар зүйлийн 36.16 дахь хэсгийг хасаж; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

63,4 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 43.1.2 дахь заалтыг хасаж:

“43.1.1.үнэт цаасны арилжааны хэлцэлд худалдан авагч талын эсрэг худалдагч тал, худалдагч талын эсрэг худалдан авагч талын үүрэг гүйцэтгэх, үүнтэй холбогдсон эрх хэрэгжүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

58,5 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.1.3 дахь заалтын “болон арилжааны бус” гэснийг, 43.1.4 дэх заалтын “эрх бүхий” гэснийг”, 43.1.5 дахь заалтын “талуудын болон системийн” гэснийг болон 43.7 дахь

хэсгийг тус тус хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

51,2 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “ажиллагааг шударга, үр ашигтай, үр дүнтэй, зохион байгуулах, системийн эрсдэлийг бууруулах үүрэгтэй.” гэснийг “ажиллагааг явуулахдаа шударга, үр ашигтай, үр дүнтэй, эрсдэлийг бууруулах зарчмыг баримтална.” гэж өөрчилж, 43.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.3.Клирингийн байгууллага гишүүнчлэлтэй (цаашид “клирингийн гишүүн” гэх) байх бөгөөд клирингийн гишүүн элсүүлэх шалгуурыг клирингийн байгууллагын журмаар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

53,7 хувиар санал дэмжигдлээ. Нямаагийн Энхболд гишүүн. Нямаагийн Энхболд гишүүн горимын санал гаргая.

Н.Энхболд: Энэ сая уг нь би дэмжсэн санал өгсөн. Тэгсэн энэ төхөөрөмжөөс болов уу, яав, минийх эсрэг гарчихлаа. Тэгээд дахиж санал хураалгахыг горимын санал гаргаж байна, дарга аа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт.

56,1 хувиар санал дэмжигдлээ.

Саналыг хүчингүйд тооцоо. Үндсэн санал хураалтын саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

61 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсгийн “клирингийн гишүүн нь гэрээт үнэт цаасны компани болон харилцагчаас” гэснийг “клирингийн байгууллага нь клирингийн гишүүнээс” гэж, 43.5 дахь хэсгийн “үнэт цаасны компани” гэснийг “клирингийн гишүүн нь” гэж тус тус өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

53,7 хувиар санал дэмжигдлээ.

Нийтдээ 56 саналтай.

22.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.6.Энэ хуулийн 43.2-т заасан зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор клирингийн байгууллага нь төлбөрийн баталгааны сан байгуулах бөгөөд сангийн үйл ажиллагааны журмыг батална. Төлбөрийн баталгааны сангийн эх үүсвэр нь клирингийн гишүүний санд оруулсан мөнгөн хуримтлалаас бүрдэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57,5 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43 дугаар зүйлийн 43.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 43.11 дэх хэсгийг хасах:

“43.9.Клирингийн байгууллага нь хуульд заасан эрх бүхий байгууллага задруулахыг шаардсанаас бусад тохиолдолд клирингийн гишүүнд холбогдох өөрт байгаа мэдээллийн нууцлалыг хадгална.”

Энэ эрх бүхий байгууллага задруулахыг шаардсан гэдэг ийм ойлголт байгаа юм байна, тийм ээ. Энэ хууль зүйн ойлголт уу. Томъёоллоо бас та бүхэн эргэж хараарай. Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “үйл ажиллагаа гэж тусгай зөвшөөрлийн бүхий” гэснийг “үйл ажиллагаа гэж энэ хуулийн 24.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий” гэж, 44.1.1 дэх заалтын “ирүүлсэн үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн үүргийг шалган баталгаажуулах” гэснийг “ирүүлсэн даалгаврын дагуу үнэт цаасны шилжүүлэг болон мөнгөн төлбөрийн гүйлгээг нэгэн зэрэг гүйцэтгэх” гэж тус тус өөрчилж, үүнтэй уялдуулан 44.1.2 дахь заалтыг хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57,5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 44 дүгээр зүйлийн 44.1.3 дахь заалтын “, сааталтай холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох” гэснийг хасаж, 44.1.4 дэх заалтын “холбогдох” гэснийг “энэ хуулийн 43.1-д заасан” гэж, мөн зүйлийн 22 дахь заалт буюу 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсгийн “мэдүүлсэн дансанд” гэснийг “нэр дээрх дансанд” гэж тус тус өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57,5 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 3 дугаар зүйлийн 25 дахь заалт буюу 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгийн “нягтлан бодох болон бусад бүртгэлдээ аудитын шалгалт хийлгэж, санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт” гэснийг “нягтлан бодох бүртгэлдээ аудитын шалгалт хийлгэж, санхүүгийн тайланг аудитын дүгнэлт гарснаас хойш аудитын дүгнэлтийн хамт” гэж өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

62,5 хувиар санал дэмжигдлээ.

27.Төслийн 4 дүгээр зүйлийн “22.9 дэх хэсгийн” гэсний дараах болон “51 дүгээр зүйлийн” гэсний өмнөх “, 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийн” гэснийг тус

тус хасаж, мөн зүйлийн “54 дүгээр зүйлийн” гэсний өмнө “51 дүгээр зүйлийн 51.1.2 дахь заалтын “төлбөрийн” гэснийг “төлбөр тооцооны” гэж,” гэж нэмэх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57,5 хувиар санал дэмжигдлээ.

28.Төслийн 5 дугаар зүйлийн “мөн зүйлийн 9.13 дахь хэсгийн “, 9.9” гэснийг,” гэснийг хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

62,5 хувиар санал дэмжигдлээ.

29.Төслийн 7 дугаар зүйлийг хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

52,5 хувиар санал дэмжигдлээ.

30.Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

52,5 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын саналууд байна.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 12 дугаар зүйлийн 12.7.2 дахь заалтын “тохиолдолд” гэсний дараа “татан” гэж”, төслийн 4 дүгээр зүйлийн “17.1 дэх хэсгийн” гэсний дараа ““Монгол Улсын”, “гадаад улсын” гэсний дараах” гэж, мөн зүйлийн “18.1 дэх хэсгийн” гэсний дараа ““Гадаад улсын”, “эрхэлж байгаа” гэсний дараах” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.38 дахь заалтын “төлбөр гүйцэтгэх болон хадгалах” гэснийг “хадгалах болон төлбөр гүйцэтгэх” гэж, мөн зүйлийн 8 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.12 дахь хэсгийн “бичиг баримтыг” гэснийг

“баримт бичгийг” гэж, төслийн 3 дугаар зүйлийн 10 дахь заалт буюу 16.3.2 дахь заалтын “санхүүгийн” гэснийг “санхүүжих” гэж, мөн зүйлийн 12 дахь заалт буюу 19.2 дахь хэсгийн “арилжаалагдах” гэснийг “арилжих” гэж, төслийн 3 дугаар зүйлийн 21 дэх заалт буюу 43.1 дэх хэсгийн, 43.2 дахь хэсгийн, 43.8 дахь хэсгийн “төв” гэснийг “байгууллага” гэж, 43.8 дахь хэсгийн “төлбөрийн үүрэг” гэснийг “төлбөр” гэж, мөн хэсгийн “төлбөр гүйцэтгэх байгууллагын” гэснийг “төлбөр тооцооны байгууллагын” гэж, 4 дүгээр зүйлийн “нийгмийн цахим сүлжээ” гэснийг “цахим орчин дахь олон нийтийн сүлжээ” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5.1.11 дахь заалтын “энэ хуульд заасан” гэснийг, мөн зүйлийн 15 дахь заалт буюу 36.17 дахь хэсгийн, мөн зүйлийн 23 дахь заалт буюу 47.9 дэх хэсгийн болон төслийн 2, 4 дүгээр зүйлийн “нарийвчилсан” гэснийг, төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 4.1.27 дахь заалтын “байгууллагын” гэсний дараах “хөрөнгийн биржийн” гэснийг, мөн заалтын “арилжаанд” гэсний өмнөх “биржийн” гэснийг, төслийн 3 дугаар зүйлийн 24 дэх заалт буюу 48.2 дахь хэсгийн “хөрөнгийн биржийн” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57,5 хувиар санал дэмжигдлээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн саналууд байна.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 30 дугаар зүйлийн 30.1.7 дахь заалтын дугаарыг “30.1.6” гэж, 9 дэх заалт буюу 39 дүгээр зүйлийн 39.4.5 дахь заалтын дугаарыг “39.4.4” гэж, 13 дахь заалт буюу 55.1.11-55.1.13 дахь заалтын дугаарыг “55.1.10-55.1.12” гэж, мөн зүйлийн 10 дахь заалт буюу 39.8 дахь хэсгийн “Хөрөнгө оруулалтын сангийн” гэснийг “Энэ хуулийн 14¹ дүгээр зүйлд зааснаас бусад хөрөнгө оруулалтын сангийн” гэж, мөн хэсгийн “батлах” гэснийг “батална” гэж тус тус өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57,5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 44¹ дүгээр зүйл, 12 дахь заалт буюу 46 дугаар зүйлийн 46.1.10 дахь заалтын “сангийн удирдлага нь” гэснийг тус тус хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

51,3 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “хуулийн этгээдийн хэлбэртэй” гэсний өмнө “энэ хуульд заасан” гэж нэмж, мөн зүйлийн “22.2 дахь хэсгийн “эрхийн” гэсний дараа “өмчлөх эрхийг” гэж” гэснийг “22.2 дахь хэсгийн “нэгж” гэсний дараа “эрхээр гэрчлэгдсэн өмчлөх” гэж” гэж өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57,5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “төвлөрүүлэх санг” гэснийг “төвлөрүүлж, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах санг” гэж өөрчилж, үүнтэй уялдуулан мөн зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “байх бөгөөд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах, сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх зорилготой” гэснийг хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Батсүхийн Саранчимэг гишүүн горимын санал гаргая.

Б.Саранчимэг: Миний санал эсрэг гарчихлаа. Би нь дэмжиж өгсөн энэ санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Батсүхийн Саранчимэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Уг саналыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт, гишүүд ээ.

57,5 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалтыг хүчингүйд тооцсон. Үндсэн санал хураалтын саналын томъёололыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

65 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Хөрөнгө оруулалтын сан” гэснийг “Энэ хуулийн 7.1-д заасан хөрөнгө оруулалтын сан” гэж өөрчилж, 16.1.9 дэх заалтыг болон 16.1.11 дэх заалтын “татан буугдах тухай болон” гэснийг тус тус хасах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.2.3 дахь заалтын “мөнгөн хөрөнгөөр зээл олгох,” гэснийг болон 15 дахь заалт буюу 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус хасаж, 12 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “26.1.5-26.1.8” гэсний дараа “, 26.1.13” гэж нэмэх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

62,5 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 4 дүгээр зүйлийн “39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “нягтлан бодогчоор” гэснийг “нягтлан бодогч, кастодианаар” гэж,” гэснийг хасаж, мөн зүйлийн “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө “30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалтын

дугаарыг “30.1.7” гэж, “45 дугаар зүйлийн” гэсний өмнө “39 дүгээр зүйлийн 39.4.4 дэх заалтын дугаарыг “39.4.5” гэж,” гэж, мөн зүйлийн “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “, 55 дугаар зүйлийн 55.1.10 дахь заалтын дугаарыг “55.1.13” гэж” гэж тус тус нэмэх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Хурал зохион байгуулах хэлтсийнхэн, техникийн хэлтсийнхэн энэ төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгая. Үүний дараа санал хураалтыг явуулна.

Санал хураалтыг явуулъя. Техникийн хэлтсийнхэн болчихсон уу?

Гишүүд саналын томъёоллийг уншиж танилцуулсан. Санал хураалт.

65,8 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

53,8 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна. Санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь заалт буюу 46.1.12 дахь заалтын “зөвлөлийн” гэсний дараа “гишүүний” гэж, 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 16 дугаар зүйлийн 16.1.10 дахь заалтын “тухайн” гэсний дараа “санхүүгийн” гэж тус тус нэмж, 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 6.2.2 дахь заалтын “өөрийн гаргасан нэгж эрхийг” гэснийг “гаргасан нэгж эрхээ” гэж өөрчилж, 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 14.6 дахь заалтын “бүрэн” гэснийг, 2 дугаар зүйлийн “нарийвчилсан” гэснийг, 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 19.3 дахь

хэсгийн “сангийн тухайд” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61,5 хувиар санал дэмжигдлээ.

Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйл буюу 46 дугаар зүйлийн 46.17 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

69,2 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “41 дүгээр зүйлийн” гэсний өмнө “32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “хувьцаа нь” гэсний өмнө “Компанийн” гэж,” гэж нэмэх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 3 дугаар зүйлийн 3.9 дэх хэсгийн “компани хэлбэртэй байна.” гэснийг “компани хэлбэртэй байж болно.” гэж өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64,1 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн “заасны дагуу” гэсний дараа “компанийн” гэж нэмэх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61,5 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 2, 3, 4, 5 дугаар зүйлийн дугаарыг “1, 2, 3, 4” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66,7 хувиар санал дэмжигдлээ.

ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг явуулъя.

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64,1 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг нь буцаана гэсэн байна шүү дээ, тийм ээ. Сая дэмжигдлээ.

Энэ ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтыг явуулъя.

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66,7 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 11.10 дугаар зүйлийн 12.21 дэх заалтын “зах зээлд, буюу бусад” гэснийг хасаж, мөн зүйлийн “Зөрчлийн тухай хуулийн 11.10, 11.26 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг” гэснийг “Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг” гэж өөрчлөх; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

69,2 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн ““12.21” гэснийг “12.22” гэж” гэснийг “12.21 дэх заалтын дугаарыг “12.22” гэж” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64,1 хувиар санал дэмжигдлээ.

Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтыг явуулъя.

1. Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

Хувь хүний орлогын орлогын албан татвараас хөнгөлөх тухай хуулийн төслийг хэлэлцье.

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66,7 хувиар санал дэмжигдлээ.

ААНОАТ-аас хөнгөлөх тухай хуулийн төслийн санал хураалтыг явуулъя.

1.Төслийг хууль санаачлагчид нь буцааа. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

65,8 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Ажлын хэсэгт баярлалаа.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлж байна.

Өнөөдөр 14 цагаас Хууль зүйн байнгын хороо хуралдана. Мөн ажлын хэсгүүд хуралдана. Маргаашийн чуулганаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэнэ.

Чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ